

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

“ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ”-д
хийсэн гүйцэтгэлийн аудитын хураангуй тайлан

АУДИТЫН КОД: ДУА-2025/27-10-ШТА-ГА

Дундговь дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439

Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ
Утас: 70592225

Цахим хаяг: Dundgovi@audit.gov.mn

Аудитор: О.Баярсайхан

Аудитор: Л.Уранбилэг

Аудитор: Г.Үүрийнтуяа

Утас: 7059-2208

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn

**“ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ”-Д ХИЙСЭН
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН**

Огноо: 2025.08.15

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	ДУА-2025/27-10-ШТА-ГА	Шалгагдсан байгууллага, нэгжийн	АЗДТГ, АИТХ, ГХУСАЗСЗ, СТСХ, Төрийн байгууллагууд
Аудитын нэр:	“ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ”		
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудит хийсэн баг, албан тушаалтан:	Гүйцэтгэл, нийцлийн аудитын баг

Хоёр. Аудитын үр дүн:**2.1 Аудитын зорилго, хамрах хүрээ:**

Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Хүү, торгуулийн орлогын төлөвлөлт нь хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэх;
- Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийг хууль, журамд нийцүүлэн төвлөрүүлсэн эсэх;
- Хүү, торгуулийн орлогын зарцуулалт үр дүнтэй эсэх;
- Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй хэрэгжсэн эсэх.

Аудитад хүү, торгуулийн орлого төлөвлөх, бүрдүүлэх, зарцуулах, хяналт хэрэгжүүлдэг төрийн байгууллагуудын холбогдох чиг үүргийн хэрэгжилт, 2023, 2024 онд хүү, торгуулийн орлогыг бүрдүүлсэн байдал, зарцуулалт, хяналт хэрэгжүүлсэнтэй холбоотой тайлан мэдээ, дансны хуулга, бусад нотлох баримт, материалыг хамруулж хийлээ.

2.2 Бүлэг А. Аудитын дүн:**А. Гол асуулт / аудитын дэд зорилт 1: Хүү, торгуулийн орлогыг үндэслэлтэй төлөвлөсөн үү?**

- **Хариулт:** Хүү, торгуулийн орлогыг урьдчилан тооцоолж, үндэслэлтэй төлөвлөх боломжгүй байна.

Хүү, торгуулийн орлогыг урьдчилан тооцоолж, бодитой төлөвлөхөд хүндрэлтэй байна.

Аймгийн хэмжээнд 2023 оны төсөвт хүү, торгуулийн орлогыг 550.0 сая төгрөгөөр төлөвлөж, 2 удаагийн тодотголоор нэмэгдүүлэн 3,420.4 сая төгрөгөөр, 2024 онд 700.0 сая төгрөгөөр төлөвлөж, 2 удаагийн тодотголоор нэмэгдүүлэн 12,583.0 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Хүснэгт-1: Хүү, торгуулийн орлогын төсвийн санал болон батлагдсан байдал

/Сая төгрөгөөр/

Орлогын төрөл	2023 он			2024 он			Нийт		
	Төсвийн санал	Төлөв лөгөө	Зөрүү	Төсвийн санал	Төлөв лөгөө	Зөрүү	Төсвийн санал	Төлөв лөгөө	Зөрүү
Хүү	-	2,540.4	2,540.4	-	629.0	629.0	-	3,169.4	3,169.4
Торгууль	550.0	880.0	330.0	700.0	11,954.0	11,254.0	1,250.0	12,834.0	11,584.0
Дүн	550.0	3,420.4	2,870.4	700.0	12,583.0	11,883.0	1,250.0	16,003.4	14,753.4

Сангийн яамнаас хүүгийн орлогыг “Дундговь-Ус” ОНӨААТҮГ-т Азийн хөгжлийн банкнаас дамжуулан зээлдүүлсэн хүүгийн төлбөрт төлөх дүнгээр 2023 онд 2,540.4 сая төгрөг, 2024 онд 629.0 сая төгрөгөөр тус тус хянасан боловч гүйцэтгэл тасарчээ.

Аймгийн Нийгмийн даатгалын газар нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 10.2¹, 11.1.4²-д заасны дагуу арилжааны банканд байршдаг сангуудын харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн орлогыг 2023-2024 онд 4.4-9.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 43.7-53.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Хүүгийн орлогыг төлөвлөхдөө өмнөх оны гүйцэтгэлд үндэслэхгүй, холбогдох тооцоо судалгааг хийхгүй, бодитой бус төлөвлөж байгаа нь суурь орлогыг бууруулахгүй байх зарчимтай нийцэхгүй байна.

Торгуулийн орлогыг өмнөх оны гүйцэтгэл, тухайн үеийн нөхцөл байдалд үндэслэн төлөвлөж байгаа бөгөөд төлөвлөгөөний гүйцэтгэл жил бүр өсч байгаа, тус орлогыг захиран зарцуулах боломжийг хууль, эрх зүйн орчноор бүрдүүлсэн зэргээс дүгнэхэд орлогыг төлөвлөж орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага байна. Мөн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх торгуулийн орлогыг урьдчилан тооцоолох тодорхой аргачлал байхгүй тул бодитой төлөвлөхөд хүндрэлтэй байна. Иймд орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журамд торгуулийн орлогыг тухайн орон нутгийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтийг харгалзан тооцох аргачлалыг бий болгож бодитой төлөвлөх шаардлагатай байна.

Хүү, торгуулийн орлогыг татварын газрын хяналт шалгалтын нөхцөл байдал болон өмнөх оны гүйцэтгэлийг харгалзан төлөвлөсөн ч зарим сумдын орлогын төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэлээс бүүруулсан байна.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтны төвлөрүүлэх торгуулийн орлогыг урьдчилан тооцоолох боломжгүй тул зөвхөн аймаг болон 15 сумдад бөөн дүнгээр торгуулийн орлогыг төлөвлөжээ.

Өмнөх 3 жилд аймгийн хэмжээгээр торгуулийн орлогын төлөвлөгөө 114.9-139.0 хувиар биелсэн боловч Адаацаг сум жил бүр, Говь-Угтаал сум 2 жил орлогын төлөвлөгөө биелээгүй тасарсан байна. Сумдын төлөвлөгөө, гүйцэтгэл харилцан адилгүй байгаа нь улсын чанартай авто зам дагуу байрлах сумд торгуулийн орлогыг илүү төвлөрүүлдэгтэй холбоотой байна.

Хүүгийн орлогыг ханшийн хэлбэлзэл, эдийн засгийн нөхцөл байдал, эх үүсвэр зэргийг харгалзан төлөвлөхгүй байгаа бөгөөд зөвхөн Азийн хөгжлийн банкнаас дамжуулан зээлдүүлсэн зээлийн гэрээнд заасан эргэн төлөлтийн хүүгийн төлбөрийн хэмжээгээр орлогод тусгаж байгаагаас жил бүр тасарч байна.

Сумдын “Хоршоо хөгжүүлэх сан”-гийн хүүгийн орлогыг төлөвлөхдөө тухайн сангийн өмнөх жилд олгосон, тайлант онд олгогдох зээлийн хүүгийн төлбөрийг үндэслэн тооцож, дараагийн онд олгох зээлийн эх үүсвэрийн нэг хэсэг болгон төлөвлөж байна. Аймгийн 15 сум сангийн нийт хүүгийн орлогыг 2023 онд 69.7 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэл 101.6 хувь, 2024 онд 64.9 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэл 99.6 хувьтай байна.

Хүү, торгуулийн орлого төлөвлөх, бүрдүүлэлттэй холбоотой хууль, эрх зүйн зохицуулалт, аргачлал тодорхойгүй, орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр заасан орлогыг улсын төсөвт төвлөрүүлж байна.

Хүү, торгуулийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлтэд тодорхой бус байдал үүсгэж буй дараах хууль эрх зүйн заалтууд байна. Үүнд:

¹ Нийгмийн даатгалын сан тус бүр банканд данстай байна.

² Сангийн хөрөнгийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулсны орлого;

- Төсвийн тухай хуульд хүү, торгуулийн орлогыг бүрдүүлэх, хуваарилах, хяналт тавих аргачлалыг тусгайлан зааж өгөөгүй, орон нутгийн төсвийн татварын бус орлогын нэг эх үүсвэр нь торгуулийн орлого гэж заасан боловч улсын төсвийн байгууллагын хувьд дээд шатны байгууллагын чиглэлээр торгуулийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлж байна.
- Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 4.2.1³, 4.2.2⁴-т гэж заасан боловч татварын бус орлого буюу торгуулийн орлогын төлөвлөлтийн талаар тодорхой тусгасан зүйл заалт байхгүй байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2-т “аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ: орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого”, 23.9.3-т “сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ: хууль тогтоомжийн дагуу сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсөвт орох бусад орлого” гэж заасан байна.

Гэвч Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлэг, Эрүүл мэндийн газар зэрэг 6 байгууллагаас 2023, 2024 ногдуулсан нийт 35.6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Зөрчил шалган шийдвэрлэх хуульд заасны дагуу зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу шалган шийдвэрлэсэн торгуулийн орлогыг тухайн нутаг дэвсгэрийн төсөвт төвлөрүүлэх нь зүйтэй.

Торгууль ногдуулах эрх бүхий нийт 13 байгууллагаас 2023-2024 онд ногдуулсан нийт торгуулиас 4,215 торгуулийг түүвэрлэн шалгахад торгуулийн хэмжээ болон торгосон үндэслэл нь Зөрчлийн тухай хуулийн холбогдох зүйл, заалттай нийцэж, зөрчлийн шинжид тохирсон байсан.

Харин Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй (жолоодлогын дадлага хийхээс бусад тохиолдолд) эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн тээврийн хэрэгсэл жолоодсон бол хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан байдаг. Энэхүү заалтаар жолоодох эрхээ хасуулсан болон жолооны үнэмлэхийн хугацаа автоматаар дууссан хүнд адилхан хэмжээний торгууль ногдуулж байна.

Зөрчлийн шинж чанар, санаатай санамсаргүй байдал, хор уршгийн түвшин зэргийг харгалзахгүй, ялгаатай зөрчилд ижил торгууль ногдуулж байгаа нь бодит нөхцөл байдалд тохирохгүй байна.

2.3 Бүлэг Б. Аудитын дүн:

Б. Гол асуулт / аудитын дэд зорилт 2: Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийг хууль, журамд нийцүүлэн төвлөрүүлсэн үү?

- **Хариулт:** Эрх бүхий албан тушаалтнаас ногдуулсан торгуулийн 99.4 хувь нь төсөвт төвлөрч, торгуулийн орлогын төлөвлөгөөний дундаж гүйцэтгэл 125.3 хувьтай байна.

2023-2024 онуудад 6 байгууллагаас 35.6 сая төгрөгийн торгуулийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2 дахь заалттай нийцэхгүй байна.

Тайлант онуудад сумдын ХХС-ийн зээлийн хүүгийн орлогыг 137.3 сая төгрөгөөр төлөвлөснөөс 135.5 сая төгрөгийн орлого төвлөрсөн буюу төлөвлөгөөний биелэлт 2023 онд 101.5 хувь, 2024 онд 99.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Хэдийгээр ХХС-ийн зээлийн хүүгийн орлого нь нийт дүнгээрээ гүйцэтгэл хангагдсан байгаа боловч зарим сумдын биелэлт хангалтгүй байна.

2023 оны байдлаар хүүгийн орлогын дутуу төлөлт 6.7 сая төгрөг байгаа бөгөөд нийт 15 сумын 6 сумд дутуу төлөлттэй байна. Ялангуяа Эрдэнэдалай, Хулд, Дэлгэрцогт, Дэрэн зэрэг сумын ХХС-ийн зээлийн хүүгийн орлогын төлөвлөгөөний биелэлт 29.6-78.1 хувьтай байгаа нь хүүгийн орлогын гүйцэтгэл хангалтгүй байна. Харин Сайнцагаан, Цагаандэлгэр, Гурвансайхан сумын ХХС-ийн зээлийн хүүгийн орлогын төлөвлөгөөний биелэлт 109.3-104.1 хувь, Сайхан-Овоо сумын хэрэгжилт 428.6 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь алданги болон өмнөх оны үлдэгдэл төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

³ Орон нутгийн төсвийн нийт орлогыг орон нутгийн төсвийн суурь орлого болон хуулиар эрх олгосны дагуу тухайн орон нутагт татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгосон орлогын нийлбэрээр;


⁴ Орон нутгийн төсвийн суурь орлогыг тухайн шатны төсөвт орох Улсын Их Хурлаас тогтоосон татварын доод хувь, хэмжээгээр тооцсон татварын болон татварын бус орлогын нийлбэрээр;

Тайлант онуудад нийт 41,611 зөрчилд 10,896.4 сая төгрөгийн торгуулийг ЭБАТ-аас иргэн, ААН-үүдэд ногдуулсан ба үүний 99.4 хувь буюу 10,833.5 сая төгрөгийн зөрчлийн торгууль төлөгдсөн байна. Төлөгдсөн торгуулийн 0.1 хувь буюу 9.1 сая төгрөг нь нийгмийн даатгалын газрын өөрийн дансанд, 0.3 хувь буюу 35.6 сая төгрөг нь улсын төсөвт төвлөрүүлсэн бол бусад 99.6 хувь буюу 10,788.9 сая төгрөг нь орон нутгийн төсөвт төвлөрчээ.

Төсвийн тухай хуулийн 23.5⁵ дугаар зүйлд улсын төсвийн татварын бус орлогын бүрдэлд хүү, торгуулийн орлого хамаарахгүйгээр зохицуулсан байна. Харин төсвийн тухай хуулийн 23.7 дугаар зүйлийн 23.7.2⁶-т орон нутгийн төсвийн татварын бус орлогыг хүү, торгуулийн орлого бүрдүүлэхээр заажээ. Тайлант онуудад дараах 6 байгууллагаас нийт 35.6 сая төгрөгийн торгуулийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Мал эмнэлгийн газар
- Эрүүл мэндийн газар
- Байгаль орчны газар
- Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар
- Хүнс хөдөө аж ахуйн газар
- Дундговь аймгийн Авто тээврийн төв

График-2: 2023-2024 оны төсөвт бүрэн төвлөрөөгүй торгуулийн орлогын мэдээлэл /сая төгрөгөөр/



Цагдаагийн газраас тайлант онуудад ногдуулсан нийт 73.9 сая төгрөгийн торгуулийг төсөвт төвлөрүүлээгүй бөгөөд үүний ихэнх хувийг хэв журам зөрчсөнтэй холбогдуулан ногдуулсан торгууль байгаа ба замын хөдөлгөөний дүрэм зөрчсөнтэй холбогдуулан ногдуулсан торгуулийн төвлөрүүлэлт өндөр байгаа нь төрийн үйлчилгээ авахад торгуулийг бүрэн төлүүлэх зохицуулалт эерэг нөлөө үзүүлж байна. Харин хэв журам зөрчсөний улмаас торгох шийтгэл ногдуулсан иргэдийн дийлэнх хувь нь

нийгмийн эмзэг бүлэгт хамаарах иргэд байгаа бөгөөд амьжиргааны түвшин, төрийн үйлчилгээг тогтмол авдаггүй зэргээс шалтгаалж торгуулийг төвлөрүүлэхэд хүндрэл үүсдэг байна.

Татварын газраас нийт 32.8 сая төгрөгийн торгуулийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй байна. Харин үлдсэн 3.0 сая төгрөгийн торгууль нь Байгаль орчны газрын улсын байцаагчийн ААН-д ногдуулсан татвар бөгөөд одоогоор зөрчил гаргасан байгууллага торгуулиа төлөөгүй, улсын дээд шүүхэд хяналтын журмаар гомдол гаргасан байна.

Тайлант онуудад аймгийн төсөвт төвлөрүүлсэн торгуулийн орлогын 44.5-53.7 хувийг хуульд заасны дагуу ГХУС үйл ажиллагааны зардалд хуваарилсан байна.

Аймгийн төсвийг хуваарилахад Төсвийн тухай хуулийн 8.5 дугаар зүйлийн 8.5.1⁷-т заасны дагуу аймгийн Засаг дарга төсвийн төслийг боловсруулан 8.5.2⁸-т заасны дагуу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэн батлуулахаар зохицуулсан байдаг.

График-4: 2023-2024 онуудын торгуулийн орлого ба түүнээс тооцсон ГХУСҮАЗ-ийн дүн /Сая төгрөгөөр/

⁵ Улсын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ: төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 12.9-д зааснаас бусад төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг; төрийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого; хууль тогтоомжийн дагуу улсын төсөвт төвлөрүүлэх бусад орлого.

⁶ орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого;

⁷ аймаг, нийслэлийн Засаг дарга, улсын зэрэглэлтэй хотын Захирагч тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Зөвлөлд өргөн мэдүүлэх;

⁸ аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл тухайн шатны жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 12 дугаар сарын 05-ны дотор батлах;

2024	2025 оны төсөвт тусгасан ГХУСАЗ	282.6, 53.7%
	2024 төвлөрүүлсэн орлого	526.0
2023	2024 оны төсөвт тусгасан ГХУСАЗ	64.8, 44.5%
	2023 төвлөрүүлсэн орлого	370.2

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1⁹-т заасны дагуу аймгийн төсөвт Цагдаагийн газрын төвлөрүүлсэн торгуулийн орлогоос аймгийн ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагааны зардал

2023 онд 137.9 сая төгрөг, 2024 онд 164.8 сая төгрөг буюу 44.5 хувь, 2025 онд 282.6 сая төгрөг буюу 53.7 хувийг хуваарилж баталсан байна.

Орон нутгийн чанартай авто замын сангийн хөрөнгийн эх үүсвэрийг Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.4-т “нийслэл, орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль;” гэж тодорхой заасан байна. Дундговь аймгийн хувьд авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасны улмаас торгох шийтгэл ногдуулж, төвлөрсөн орлогоос авто замын санд төвлөрүүлэн замын арчлалт, засварын ажилд зарцуулж байна.

2.4 Бүлэг В. Аудитын дүн:

В. Гол асуулт / аудитын дэд зорилт 3: Хүү, торгуулийн орлогын зарцуулалт үр дүнтэй байна уу?

- **Хариулт:** Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлын 32.0-40.9 хувийг зориулалт бусаар зарцуулсан нь төсвийн үр дүнг бууруулсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд 2023 онд нийт 138.0 сая төгрөгийн санхүүжилтээр 4 зорилтод хамаарах 47 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр, 2024 онд нийт 164.8 сая төгрөгийн санхүүжилтээр 5 зорилтод хамаарах 53 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Хүснэгт-9: Аймгийн болон зарим сумдын ГХУСАЗСЗ-ийн батлагдсан санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэл /Сая.төгрөгөөр/

№	Сумын нэр	2023 он			2024 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Аймаг	138.0	137.9	0.1	164.8	164.7	0.1
2	Дэлгэрхангай	4.0	3.9	0.1	5.0	5.0	0.0
3	Говь-Угтаал				5.0	5.0	0.0
4	Гурвансайхан				2.0	2.0	0.0
5	Сайнцагаан	30.0	30.0	0.0	50.0	37.8	12.2
6	Нийт	172.0	171.8	0.2	226.8	214.4	12.4

Хүснэгтээс харахад 2023 онд Сайнцагаан, Дэлгэрхангай, 2024 онд Сайнцагаан, Дэлгэрхангай, Говь-Угтаал, Гурвансайхан сумдаас бусад сум гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төсөв батлуулаагүй байна. Аймгийн ГХУСАЗСЗ 2023 онд нийт төсвийн 80.2 хувийг, 2024 онд нийт төсвийн 76.8 хувийг зарцуулсан байна.


Аймгийн ИТХ-ын мэргэжилтэн сумдын зөвлөлийн нарийн бичгийн даргатай жил бүр ГХУС ажил хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, аймгийн ИТХ-ын ГХУСАЗСЗ-өөс 2023 онд 17.5 сая, 2024 онд 5.0 сая, нийт 22.5 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна.

Хүснэгт-10: Аймгийн ГХУСАЗСЗ-өөс 2023, 2024 онд сумдын зөвлөлд олгосон санхүүжилт /Мян.төг/

⁹зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ.

Он	Өлзийт	Хулд	Эрдэнэдал ай	Дэлгэрхангай	Дэлгэрцогт	Дэрэн	Өндөршил	Гурвансайхан	Баянжаргалан	Цагаандэлгэр	Говь-Угтаал	Нийт
2023	568.5	3,000.0	7,221.5	2,293.0	500.0	500.0	500.0	1,000.0	1,000.0	1,000.0		17,583.0
2024		500.0		3,000.0							1,500.0	5,000.0

Аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2023, 2024 оны зарцуулсан зардлыг ангиллаар харуулбал:



Графикаас харахад тус онуудад нийт зардлын дийлэнх хувийг сургалт сурталчилгаа, тоног төхөөрөмжийн зардалд зарцуулсан байна. Мөн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5¹⁰ дэх заалттай нийцээгүй, төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил тус онуудад 32.0-40.9 хувийг эзэлж байна.

Аудитаар аймгийн ГХУСАЗСЗ-ийн зарцуулалтыг шалгахад төсвийг зориулалт бус, хэмнэлтгүй зарцуулсан 72.9 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

- ✗ Аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын ажлын албанд компьютер, лед телевизор, зургийн аппарат гэх мэт бусад төрлийн тоног төхөөрөмж худалдан авах зардал;
- ✗ Зөвлөлийн хуралдааны хоол, ундны зардал;
- ✗ Цагдаагийн албан хаагч нарыг Үндэсний шигшээ багийн бэлтгэл сургалтын зардалд;
- ✗ Эрдэнэдалай сумын ахмадын хорооны үйл ажиллагаанд болон урлаг соёлын арга хэмжээ, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, эвэнт арга хэмжээ зохион байгуулахад;
- ✗ Ном хандивлах эвэнт арга хэмжээ зохион байгуулахад ном худалдан авах гэх мэтчилэн зардалд зарцуулжээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг өмнөх оноос 54.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан боловч гэмт хэрэг 14.6 хувь, зөрчил 5.1 хувиар тус тус өссөн байна.

Өссөн гэмт хэргээс авч үзэхэд ХЭМХБ-ын эсрэг гэмт хэрэг 38 буюу 32.5 хувиар, хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 19 буюу 67.8 хувиар тус тус

¹⁰ 46.5.1.гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хууль сахиулах болон төрийн бус байгууллага, иргэдээс иргэд, байгууллагын дунд зохион байгуулж байгаа сургалт, сурталчилгааны ажлын зардлыг санхүүжүүлэх;
 46.5.2.энэ хуулийн 34 дүгээр зүйлд зааснаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон хүн, хуулийн этгээдийг шагнаж, урамшуулах;
 46.5.3.энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүргээ биелүүлж яваад эрүүл мэндээрээ хохирсон буюу амь насаа алдсан тохиолдолд түүнд болон ар гэрт нь олгох тэтгэвэр, тэтгэмжийн зөрүү, зардал, нөхөн төлбөрийг төлөх;
 46.5.4.гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд болон шүүхийн шинжилгээний байгууллагаас хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн зардлыг санхүүжүүлэх;
 46.5.5.гэмт хэрэг, зөрчил үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа болон үйлдсэн тухай мэдээллийг иргэдээс авах төлбөрийн зардлыг санхүүжүүлэх;
 46.5.6.гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу үнэлгээ, судалгаа хийх, тэдгээрийг хэлэлцүүлэх, хуульд заасан дүрэм, журам, заавар боловсруулах;
 46.5.7.тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх арга, ажиллагааны талаарх судалгааны ажилд зарцуулах;
 46.5.8.олон нийтийн цагдаагийн урамшуулал, эрүүл мэндийн даатгалын зардлыг санхүүжүүлэх;

өссөн нь дийлэнх хувийг эзэлж байна. Харин буурсан гэмт хэргийн хувьд хулгайлах гэмт хэрэг 24 буюу 60 хувь, залилах гэмт хэрэг 10 буюу 27.7 хувиар буурсан нь дийлэнх хувийг эзэлж байна.

Гэмт хэргийн илрүүлэлт өссөн нь ГХУС зардлыг нэмэгдүүлэн баталж, зарцуулснаар илрүүлэлт сайжирч, үр дүнд хүрсэн байх боломжтой боловч тус зардлын 2023 онд 32.0 хувь, 2024 онд 40.9 хувийг зориулалт бусаар зарцуулсан нь төсвийн үр ашгийг бууруулах, нийгэм, эдийн засагт нөлөөлөх эерэг нөлөөллийг бууруулах үр дагаврыг бий болгож байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн хүүгийн орлогын зарцуулалтын хувьд:

Сумдын хоршоо хөгжүүлэх сангаас 2023 онд 70.8 сая төгрөг, 2024 онд 64.7 сая төгрөг нийт 135.5 сая төгрөгийн хүүгийн орлого орж, 2023, 2024 онд нийт хүүгийн орлогоос 26.0 сая буюу 18.2 хувийг зарцуулсан нь “Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 2.7-д заасантай нийцэж байна. Үүнээс журмын дагуу зарцуулсан байдлыг дурдвал:

- ✓ Хоршоонд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтын зардалд 7.0 сая төгрөг;
- ✓ Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц, үр дүнд хяналт тавих үйл ажиллагаа болон программ хангамжийн зардалд 11.3 сая төгрөг;
- ✓ Ажил хариуцсан мэргэжилтнийг урамшуулахад 7.6 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

Хүү, торгуулийн орлогоор санхүүжүүлсэн арга хэмжээ нь ил тод, олон нийтэд мэдээлсэн байна.

Аймгийн ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөөндөө 2023, 2024 онд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхээр удирдлага, зохион байгуулалтын ажил хэрэгжүүлэх арга хэмжээ авах чиглэлээр 10, хэрэгжүүлсэн хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлтийг хангуулах талаар 4, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тусгай чиглэлээр 27, хяналт, шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр 5 ажлуудыг тус тус хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Төлөвлөсөн ажил, арга хэмжээний хүрээнд арга хэмжээнүүдийг зохион байгуулж аймгийн “Дундговийн амьдрал” сонин, facebook, аймгийн ИТХ болон ЗДТГ-ын сайтуудаар олон нийтэд мэдээллийг хүргэсэн байна.

Аймгийн ИТХ-ын төсөвт батлагдсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг Шилэн дансны цахим хуудсанд оруулсан байдлыг хянаж үзэхэд 2023 онд 137.9 сая төгрөгийн 59 мэдээлэл, 2024 оны 164.7 сая төгрөгийн 73 мэдээллийг мэдээлсэн байна.

2.5 Бүлэг Г. Аудитын дүн:

Г. Гол асуулт / аудитын дэд зорилт 4: Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй хэрэгжиж байна уу?

- **Хариулт: Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг хэрэгжүүлээгүй байна.**

Хүү, торгуулийн орлогын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан байхгүй байна. Энэ нь торгуулийн орлого бүрдүүлэлтийн явц болон үр дүнд хяналт тавих боломжгүй байдлыг бий болгож байна.

Зөрчил, торгууль, шийтгэлийн мэдээллийг нэгтгэн бүртгэх, орлого бүрдүүлэлтийн гүйцэтгэлийг хянах байгууллага хооронд мэдээлэл солилцох, нэгдсэн бүртгэл, хяналтын систем бүрэн бий болоогүй, байгууллага бүр өөрийн салбарын бүртгэлийн программ хангамжийг тус тусдаа ашиглаж байна. Үүнд:

- Прокурорын газар дотооддоо “Цахим мэдээллийн систем”-ийг ашиглан Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж, эрх бүхий албан тушаалтны шалгасан зөрчлийн хэргийн хяналтыг хэрэгжүүлж байна. Мөн ezurchil.mn системийг цагдаагийн байгууллагатай хамтран туршилтын байдлаар ашиглаж байна.
- Цагдаагийн газар “Е-Portol” аппликейшн-ыг ашиглан бэлэн бус төхөөрөмжөөр торгууль ногдуулж, тухайн орон нутгийн төрийн сангийн данстай шууд холбогдон орлогыг төвлөрүүлж байна. Мөн бэлэн бус торгуулийн “Од” программыг дотооддоо ашиглаж, бэлэн бус торгуулийн ногдуулалт, төлөлтөд хяналт тавьдаг.

- Татварын газар нь “Tais” системээр орлогыг бүртгэж, ТЕГ-ын Татвар хураалтын удирдлагын газар нэгдсэн сан үүсгэдэг.
- Нийгмийн даатгалын газар “SIGOS” системд орлогыг бүртгэж, НДЕГ-ын хэмжээнд нэгдсэн сан үүсгэдэг байна.

Торгуулийн төлбөрийг Smartcar.mn, E-Mongolia систем, “SocialPay”, татварын “ebarimt.mn, арилжааны банкнуудын аппликейшн, “ХурДан” киоск машин, MostMoney, Toki зэрэг цахим хэрэгслийг ашиглан төлж байна.

Тухайлбал: Цагдаагийн газар хувьд бэлэн бус төхөөрөмжөөр ногдуулсан торгуулийг 2024 онд цахим хэрэгсэл ашиглан төлсөн тохиолдол өмнөх оноос 13.4 мянгаар өсөж 20.1 мянга болж нэмэгдсэн, 2025 оны 7 сарын байдлаар 9.2 мянган торгуулийг төлсөн байгаа нь шийтгүүлсэн этгээд цахим хэрэгсэл ашиглан хялбараар төлөх сонирхол жил бүр нэмэгдэх хандлагатай байгааг илтгэж байна. Энэ нь торгуулийн орлого бүрдүүлэлтэд мөн эергээр нөлөөлж байгааг аймгийн төсөвт төвлөрүүлсэн торгуулийн орлогын гүйцэтгэлээс харж болно.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах эрх бүхий этгээдийн зөрчил шийдвэрлэлтийг бүртгэх, мэдээлэл солилцох, торгуулийн орлогын бүрдүүлэлтэд хяналт тавих нэгдсэн систем байхгүй тул нутгийн захиргааны байгууллага, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч хяналт тавих боломж бүрдээгүй байна.

Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад эрх бүхий байгууллагуудаас хяналт хэрэгжүүлээгүй байна.

Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлтэд чиглэсэн хяналт шалгалт хийгээгүй ч аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хүрээнд Төрийн аудитын байгууллага болон Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба жил бүр санхүүгийн тайлан, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлж иржээ.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч, Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумдын санхүүгийн алба нь хүү, торгуулийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, хяналт тавих чиг үүрэгтэй.

Хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд орлого бүрдүүлэлтийг төрийн сангийн дансны хуулга, орлогын гүйцэтгэлээр хянаж байгаа бөгөөд торгууль ногдуулалтын хэмжээ, төлөлтийн явцад хяналт тавих тогтолцоо бий болоогүй, хяналт сул байна. Харин зарцуулалтын хувьд анхан шатны баримтыг үндэслэн хяналт хэрэгжүүлж байгаа ч зарцуулсан төсвийн үр дүнд тавих хяналт хангалтгүй байна.

Аудитын хамрах хугацаанд хөндлөнгийн байгууллага, иргэн, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагаас хүү торгуулийн орлогын бүрдүүлэлт зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн хэмжээнд хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлтийг зөвхөн орлогын гүйцэтгэлээр хянаж байгаа нь ногдуулсан торгуулийн биелэлт, хугацаа хэтрэлтэд тавих эрх бүхий албан тушаалтны хяналт орхигдсон, нэгдсэн цахим хяналтын систем дутагдалтай байгааг харуулж байна.



Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Үүнд:

1. Хүү, торгуулийн орлогыг урьдчилан тооцоолж, бодитой төлөвлөхөд хүндрэлтэй байна.
2. Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журамд торгуулийн орлогыг тухайн орон нутгийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтийг харгалзан тооцох аргачлалыг бий болгож бодитой төлөвлөх шаардлагатай байна.
3. Хүү, торгуулийн орлогыг Татварын газрын хяналт шалгалтын дүн болон өмнөх оны гүйцэтгэлийг харгалзан төлөвлөсөн ч зарим сумдын орлогын төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэлээс бууруулсан байна.
4. Хүү, торгуулийн орлого төлөвлөх, бүрдүүлэлттэй холбоотой хууль, эрх зүйн зохицуулалт, аргачлал тодорхойгүй байна.
5. Торгох шийтгэлээр шийтгэгдсэн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй хэдий ч үүргийн хэрэгжилтийг хангахад уян хатан нөхцөл бий болгосон нь торгуулийн орлого бүрдүүлэхэд эерэг нөлөө үзүүлж байна.
6. Тайлант онуудад ЭБАТ-аас ногдуулсан 106.7 сая төгрөгийн торгуулийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй байна.
7. Эрх бүхий албан тушаалтнаас ногдуулсан торгуулийн 99.4 хувь нь төсөвт төвлөрч, торгуулийн орлогын төлөвлөгөөний дундаж гүйцэтгэл 125.3 хувьтай байна.
8. 2023-2024 онуудад 6 байгууллагаас 35.6 сая төгрөгийн торгуулийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 23.7.2 дахь заалттай нийцэхгүй байна.
9. Тайлант онуудад аймгийн төсөвт төвлөрүүлсэн торгуулийн орлогын 44.5-53.7 хувийг ГХУС үйл ажиллагааны зардалд хуваарилсан байна..
10. ГХУС үйл ажиллагааны зардлыг 32.5-40.9 хувийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.
11. Хүү, торгуулийн орлогоор санхүүжүүлсэн арга хэмжээг ил тод, олон нийтэд мэдээлсэн байна.
12. Хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэн шилэн дансны цахим хуудсаар мэдээлсэн байна.
13. Хүү, торгуулийн орлогын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан байхгүй байна.



Зөвлөмж

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн ГХУСАЗСЗ-д:

- Аймгийн ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийг баримтлан төсвийг хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах;

Аймгийн Засаг дарга, Санхүү, төрийн сангийн хэлтэст:

- Торгуулийн орлогыг тооцоо, судалгаа, өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн суурь орлогыг бууруулахгүй төлөвлөх;
- Хүү торгуулийн орлого бүрдүүлэлт, гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллах;
- Төсвийн тухай хуулийн 23.7 дахь заалтыг хэрэгжүүлэн тайланд дурдсан 6 байгууллагын эрх бүхий албан тушаалтнаас ногдуулсан торгуулийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, орон нутгийн төсвийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх;

Сумдын Засаг дарга нарт: /Хулд, Дэлгэрцогт, Дэрэн, Адаацаг, Баянжаргалан, Цагаандэлгэр, Эрдэнэдалай, Сайнцагаан/

- Сумдын “Хоршоо хөгжүүлэх сан”-ийн хүүгийн орлогын бүрдүүлэлтэд хяналт тавьж, өмнөх онуудын дутуу төвлөрсөн 10.5 сая төгрөгийн хүүгийн орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлэх;

Аймгийн Цагдаагийн газарт:

- Өмнөх онуудын торгуулиас төсөвт төвлөрөөгүй 73.9 сая төгрөгийн төлбөрийг нөхөн төлүүлэх арга, хэмжээг зохион байгуулах, цаашид орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлж байх;

Аймгийн Татварын газарт:

- Өмнөх онуудын ногдуулсан торгуулиас барагдуулаагүй 32.8 сая төгрөгийн төлбөрийг нөхөн төлүүлэх арга, хэмжээг зохион байгуулах, цаашид орлогыг бүрэн барагдуулж байх;



Санал

Нийслэл дэх Төрийн аудитын газарт уламжлах санал:

1. Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журамд торгуулийн орлогыг тухайн орон нутгийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтийг харгалзан тооцох аргачлалыг бий болгож мөрдүүлэх;
2. Мал эмнэлгийн газар, ХХААГ, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Эрүүл мэндийн газар, Байгаль орчны газар, Авто тээврийн төвөөс оногдуулсан торгуулийн орлогыг Төсвийн тухай хуульд заасны дагуу орон нутгийн төсөвт төвлөрүүлэх чиглэлээр холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжлах;
3. Зөрчлийн тухай хуулийн 14.7.1 хэсэгт заасан “жолооны үнэмлэхийн хугацаа дууссан” зөрчилд ялгаатай шийтгэл ногдуулах зохицуулалтыг холбогдох хуулиудад тусгаж өөрчлөх;
4. Улсын хэмжээгээр зөрчлийг бүртгэх, шийдвэрлэх, хэрэгжилтийг хянах нэгдсэн системийг бий болгох;

Монгол Улс, Дундговь аймаг 48090, Сайнцагаан сүм, Нарлаг
баг, Нутгийн удирдлагын ордон Утас/Факс: 70-59-24-39
E-mail: dundgovi@audit.gov.mn 